

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-12

---

*1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/* 3-6

*2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай* 6-12

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
11 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 28 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, Б.Жаргалмаа;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Мөнхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл үг хэлэв.

**Н.Энхболд:** “Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, нэр дэвшигч Л.Өлзийсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлаас Цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлсэн саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулав.

Нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, нэр дэвшигч Л.Өлзийсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

**Н.Энхболд:** Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Лувсандоржийн Өлзийсайханыг нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 37 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 05 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
14 цаг 28 минут.

### **ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Харьяалагддаг гишүүн, юу хаашаа ирц цаашаа орчхов? Ганболд гишүүн ирсэн байна, Доржханд гишүүн ирсэн, Тогтохсүрэн гишүүн ирсэн, Энхболд гишүүн ирсэн, Занданшатар гишүүн ирсэн, Пүрэвдорж гишүүн ирсэн, Эрдэнэбат гишүүн ирсэн, Бямбацогт гишүүн ирсэн, Мөнх-Оргил гишүүн ирсэн, Сарангэрэл гишүүн ирсэн. Ирц хангалттай болсон тул 2023 оны 11 сарын 15-ны өдрийн ТББХ-ны хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдөр 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөөд байна. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэнэ. ҮХЦ-ийн гишүүнд нэр дэвших тухай асуудал бас ийм 2 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад асуух, санал гаргах гишүүн байна уу? Алга байна, хэлэлцэх асуудлаа баталлаа. Горимын саналтай гишүүн байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/**

ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг

хэлэлцэж эхэлнэ. Тайлбарт Төрийн албаны тухай хуулийн 68.2-т зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр 1 хүний, төрийн албан хаагчийн төлөөлөл 2 хүний нэрийг төлөөлөл 2 хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албанд 15-аас доошгүй жил ажилласан, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн, дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна гэж заасан. Мөн намын удирдах аливаа улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, сүүлийн нэг жилийн хугацаанд эдгээр албан тушаалд ажиллаж байсан хүнийг нэр дэвшүүлэхгүй. Нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн хамаарал бүхий этгээд байж болохгүй гэсэн ийм заалтуудтай ийм асуудлыг бид нар хэлэлцэх гэж байна. Энэ юмыг нь танилцуулчихна. Нөгөө нэг байгаа хүмүүсийн хугацаа дууссан тухай юмнуудыг нь хэлчихье. Тийм. Тэр маань хаана байгаа билээ? Энд байгаа.

Өнөөдөр ажиллаж байгаа ТАЗ-ийн 2 гишүүний хугацаа нь бүрэн эрхийн хугацаа дууссан байгаа. Баатарзориг, Баатарсайхан, Цэдэндамба, Цэдэндамба нарын. Тэгээд энэ хугацаа нь дууссан гишүүдийн оронд холбогдох хуульд заасан байгууллагуудаас зөвлөлийн гишүүнд нэр дэвших, дэвшүүлэх саналууд ирсэн. Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлэх тухай албан тоот ирсэн. Төрийн албаны тухай хуулийн 68 дахь хэсэгт зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЗГХЭГ тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албанд 15-аас доошгүй жил ажилласан, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна гэж заасан. Мөн энэний дагуу Монгол

Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлж томилсон Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригийн бүрэн эрх эрхийн хугацаа дуусгавар болсон тул дээр дурдсан хуулийн шаардлага хангасан Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Нэргүйн Мягмарыг ТАЗ-ийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж, танилцуулга, холбогдох бусад материалыг хүргүүлж байна. Зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү гэсэн Ерөнхий нарийн бичгийн гарын үсэгтэй нэг хүсэлт ирсэн байгаа. Нөгөөдхийг нь.

Мөн Монгол Улсын ЗГ-аас санал ирүүлсэн. Санал хүргүүлэх тухай. Лхагвын Лхагвасүрэнг, Цэдэвсүрэнг Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэн томилуулах саналыг Улсын Их Хуралд хүргүүлж байна. Чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү гэсэн Монгол Улсын Ерөнхий сайдын гарын үсэгтэй ийм бичиг ирсэн. Би эхлээд энэ 2 хүний товч намтрыг танилцуулчихъя. Тэгээд дараа нь тогтоолын төслөө танилцуулна. Тэгээд асуугаад, санал хэлээд явчихъя.

Нэр дэвшигч Нэргүйн Мягмар 76 оны 12 сарын 21-нд төрсөн. Булган аймгийн Дашинчилэн суманд сурсан. МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль бакалавр, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн дээд сургууль, АНУ-ын American university-ийн Вашингтон коллеж болоод магистр хамгаалсан. 99-өөс 2006 онд МУИС-д Хууль зүйн дээд сургуульд багш хийсэн биш, Нэргүйн Мягмар. ХЗДХЯ-нд ахлах мэргэжилтэн, газрын дарга, Хууль зүйн үндэсний хүрээлэнд захирал, Монголын хөлөг онгоцны бүртгэл компанид захиргааны менежер, Хууль зүйн яаманд газрын дарга, АНУ дахь Сан Франциско дахь Ерөнхий консулын газар консул, АХБ-ны санхүүжилттэй төслийн менежер, ЗГХЭГ-т Хууль эрх зүйн газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газарт Хууль, эрх зүйн газрын дарга 23 оноос эхлээд хийж байгаа. Зэрэг хамгаалсан сэдэв нь төрийн албанд

захиргааны албан хаагчийг ишлэж сонгох зарим асуудал магистрын зэрэг хамгаалсан. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн дээд сургуульд, Америкийн Вашингтоны хуулийн коллежийн Америк их сургуульд бичсэн. Судалгааны ажлын чиглэл захиргааны эрх зүй, төрийн алба, татварын эрх зүй, оюуны өмч чиглэлээр хийж байсан. Хуульчдын холбооны гишүүн, Захиргааны эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн ийм хүн байна.

Лхагвын Цэдэвсүрэн 67 онд төрсөн, төрийн жинхэнэ албанд 15-аас доошгүй жил ажилласан байдлыг танилцуулбал 85 оноос эхэлж ажилласан. Хотын барилга засварын нэгдсэн трестэд засал чимэглэлчин, Соёлын яаманд хуулийн зөвлөх, Гэгээрлийн яаманд мэргэжилтэн, хуулийн зөвлөх, БСШУЯ-ны хуулийн зөвлөх, мэргэжилтэн, мөн яамны хэлтсийн дарга, мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, яамны нэр солигдсоноос хойш мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын даргаар ажиллаж байсан. Хуулийн хэлтсийн даргаар ажиллаж байсан. Мөн яамныхаа ТНБД-аар, 20-оос 21 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдаар, 21 оноос онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 21 оноос БШУЯ-ны ТНБД-ын ажил тус тус хийж байсан ийм хүмүүс байна.

Эдгээр хүмүүстэй холбогдуулаад Байнгын хорооноос дэмжигдвэл дараах тогтоол гарах ёстой. Би тогтоолын төслөө уншаад танилцуулъя. Бид нар бол өнөөдөр хүнийхээ асуудлыг ярихгүй. Ямар ч байсан сонсголынхоо тов, сонсгол дарагч даргалагчаа тогтоох ийм Байнгын хорооны тогтоол гарах ёстой. Тэгэхдээ энэ дээрээ ямар, ямар хүмүүсийн сонсголыг хийх вэ гэдгээ бас зааж өгөх ёстой. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэг, 119 дүгээр зүйлийн 119.1 дэх

хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТББХ-ноос тогтоох нь.

1.Төрийн ТА3-ийн гишүүнд нэр дэвшигч Лхагвын Цэдэвсүрэн, Нэргүйн Мягмар нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2023 оны 12 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.ТА3-ийн гишүүнд нэр дэвшигч нартай хийх нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдыг томилсугай.

3.Нэр дэвшигчид хандан асуух асуулт, саналыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4.Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг ТББХ Энхболдод даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байгаа. Нэр дэвшигчтэй, нэр дэвшигчдийн талаар санал хураахгүй. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад, нэр дэвшигчтэй холбогдуулж асуух санал гишүүд байвал нэрээ өгье. Тов, тов сонсгол байгаа. Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Сая Энхболд дарга маань нэр дэвшигчдийн талаар өнөөдөр ярихгүй гэж хэлж байгаа боловчиг 3 төрийн өндөр албан тушаалд нэр дэвшээд ороод ирж байгаа 3 хүн маань бол төрийн ажлын туршилагатай.../үг тасрав/

**Н.Энхболд:** 2. Нэргүй, Цэдэвсүрэн, Цэдэвсүрэн тийм.

**Д.Сарангэрэл:** Цэцийнх нь өөрөө тийм ээ. Би ч одоо эмэгтэйчүүдээ дэмжиж үг хэлэх гээд ингээд яг яараад. Тийм манай Цэдэвсүрэн нэр дэвшигч маань бас Боловсролын сайдаар ажиллаж байсан, нэг кабинетад ажиллаж байсан. Ажил хэрэгч ийм мундаг эмэгтэй ингээд ТА3-д нэр дэвшээд ороод ирж байна. Манай Мягмар дарга ч гэсэн төрд олон жил ажиллаж байгаа, ЗГХЭГ-т ажиллаж байсан ингээд үнэхээр энд байж болохуйц төрийн ажлыг бол их тийм хариуцлагатай хийж чадах ийм хүмүүсийн нэр орж ирж байгаад бол бас баяртай байна. Тэгээд дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Тэгээд би шинжээчдийн ажиллахад ч гэсэн, Байнгын хороо манай Ганболд дарга маань ингээд томилогдоод ажиллах юм байна, ажиллахад их амар байх болов уу гэж бодож байна. Энэ үнэхээр төрийн ажлын туршилагатай, хариуцлагатай хүмүүс бол орж ирж байгаа юм байна.

**Н.Энхболд:** Баярлалаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулттай гишүүн байна уу? Энэ материал нь болбол нэлээд эрт ирсэн юм. Тийм яах вэ сонсголоо явуулах хугацаанд тэрийг нь нөхөж авч болох л байх даа. Тэгье, тэгье. Байнгын хорооны ажлын алба анхаараад юмыг нь явуулаад, авчхаарай. Сонсгол эхлэхээс өмнө 14 хоногийн зай байна. Тогтоолтой холбогдуулж асуух гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Санал хураалт явуулна. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 11 гишүүн санал хураалтад оролцож, 10, 9 гишүүн дэмжсэнээр болж байна. Бямбацогт сайд, Занданшатар дарга нарын саналыг дэмжсэнээр авч протоколд тусгах юм

шүү. ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

14.40 цаг

### **Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай**

Дараагийн асуудалдаа оръё. Үндсэн хуулийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвших тухай асуудлыг Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танилцуулна. Ер нь болбол Цэцийн гишүүнд нэр дэвшиж байгаа хүмүүсийг аль байгууллагаас дэвшүүлж байгааг нь харгалзаад 2 Байнгын хороогоор орж байгаа. Их Хурлаас дэвшиж байгаа хүнийг ТББХ-гоор, санал, дүгнэлтээ ХЗБХ-нд, нөгөө бусад газруудаас нэр дэвшиж байгаа хүмүүсийг ХЗБХ-гоор хэлэлцэж явах ёстой. Үүний дагуу Их Хурлын дарга Занданшатар нэр дэвшигчийнхээ талаар танилцуулна. Танилцуулгыг та бүхэнд хүргэсэн байгаа. Нэр дэвшигчийг, ороод ирээд суучихсан байна. Занданшатар даргын микрофоныг өгье.

**Г.Занданшатар:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэгд зааснаар Үндсэн хуулийн цэцийн гишүүний 3-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 3-ыг Монгол Улсын Их Хурлаас, 3-ыг Монгол Улсын Дээд шүүхээс нэр дэвшүүлж томилно гэж заасан. Мөн Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Цэцийн 9 гишүүний 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэж заасан. Дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурлаас Д.Одбаярыг ҮХЦ-ийн

гишүүнд нэр дэвшүүлэн, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнээр 6 жилийн хугацаатай томилсон. Одоо хугацаа нь дуусгавар болсон байгаа. Тэгээд хуульд заасан хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Монгол Улсын үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх, нэг дэх хэсэг, Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн удирдлага болгон Улсын Их Хурлаас Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэхээр санал болгож байна.

Лувсандоржийн Өлзийсайхан нь 1975 онд төрсөн, 48 настай. 1993 онд нийслэлийн 10 жилийн 50 дугаар сургууль, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2002 онд тус сургуулийг Хууль зүйн магистрын зэрэгтэй төгссөн. 2021 онд Парламентын хуралдааны дэг, эрх зүйн харьцуулсан шинжилгээ нэг сэдэвт бүтээлээр хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. Дэд профессор цолтой. 1998, 1998 оноос хойш хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт тасралтгүй 25 жил ажиллаж байна. Өлзийсайхан нь 1998-аас 2002 онд Улсын Багшийн их сургуульд багш, 2002-оос 2016 онд Монгол Улсын Хууль зүйн сургуульд багш, ахлах багш, 2007-гоос 2012 онд Улсын Их Хурлын Тамгын газарт зөвлөх, экспертний хэсгийг хариуцсан ахлах зөвлөх, 2012 онд Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх, 2013-аас 15 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн газрын дарга, 2015-аас 2017 онд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн шүүгч, 2017-гоос 2018 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, 2018-аас 19 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлага, зохицуулалтын газрын дарга, 2019 онд Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх, ахлах зөвлөх, 2019

онд 2019 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт ЕНБД-аар ажиллаж байгаа болно.

Түүнчлэн Лувсандоржийн Өлзийсайхан нь МУИС-ийн Хууль зүйн сургуульд 15 жил багшилж, эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй, парламент судлалын чиглэлээр 10 гаруй нэг сэдэвт бүтээл, ном, гарын авлага туурвиж, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, судалгааны ажил бичиж, эрдэмтэн судлаачид болон олон нийтийн хүртээл болгосон. Шүүх эрх мэдлийн болон хууль тогтоох үйл ажиллагааны практикийг судлах чиглэлээр АНУ, ХБНГУ, Япон, Франц, БНСУ, Швейцарын холбооны улсад мэргэжил дээшлүүлсэн.

Лувсандоржийн Өлзийсайхан 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах эхний шатнаас хэлэлцэн батлах хүртэл бүхий л үйл явцад Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагын хувиар манлайлан ажиллаж, Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан. Тодруулбал Үндсэн хуульд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын хариуцлага үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн парламентын эрх зүйн орчны болон бусад шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах чиглэлээр үр дүнтэй ажиллаж байна. Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийг ард түмнээр хэлэлцүүлж, санал авах, улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлаар үндэсний хэмжээнд Зөвлөлдөх санал асуулга явуулах зэрэг төрийн томоохон ажил, түүхэн үйл хэргүүдийг удирдан зохион байгуулахад бодлого хэрэгжилтийн түвшинд мэргэжлийн өндөр ур чадвар гарган хариуцлагатай ажилласныг тэмдэглэж байна.

Иймд ҮХЦ-ийн гишүүнд тавигдах хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэсэн үндсэн шаардлагыг хангаж байгаа, хууль зүйн эрдэм шинжилгээ судалгаанаас эхлэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт 25 жил хууль, эрх зүйн мэргэжлийн ажил эрхэлж буй Лувсандоржийн Өлзийсайханыг ҮХЦ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Энхболд:** Занданишатар даргад баярлалаа. Нэр дэвшүүлсэн Их Хурлын дарга, нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгье. Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Доржханд гишүүн. Сарангэрэл гишүүний микрофон өгье.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа ҮХЦ-ийн гишүүнд манай Өлзийсайхан дарга орж ирж байна. Манай Өлзийсайхан дарга парламентын ЕНБД-аар бол мундаг ажилласаар ирсэн дээ. Манай Занданишатар дарга Өлзийсайхан даргын чинээнд ядаж чинээнд нь очихгүй юм гэхэд дутахгүй ийм даргыг олоход бас амаргүй байх болно байх. Ер нь гар мухардах тал руугаа шүү. Өлзийсайхан даргатайгаа олон жил хамтарч ажиллалаа. Үнэхээр ажил хэрэгч. Өнөөдөр энэ ҮХЦ-ийн гишүүнд нэр дэвшээд, тодорхойлолт, бүтээлийнх нь жагсаалтыг харахад бол үнэхээр бахархаж байна. Хууль зүйн ухааны доктор, дэд профессор. Ингээд 20 бүтээлтэй, 13 гарын авлага, өгүүлэлтэй үнэхээр мундаг эрдэмтэн хүн байна. Түүнээс гадна манай Өлзийсайхан дарга ер нь ямар ч гишүүний гишүүн ямар ч асуудал тавихад хариуцлагатай, хүндэтгэлтэй ханддаг ийм том чанар бий.

Ер нь бол бас энэ хугацаанд чинь янз бүрийн асуудал ингээд гарчхаад Өлзийсайхан даргадаа хэлэхэд бол яг зарчмын дагуу, журмын дагуу асуудлыг ингээд шийдэж өгдөг тэр асуудлуудыг

яриад ч яах вэ. Ийм хариуцлагатай хүн өнөөдөр ҮХЦ-ийн гишүүнд нэр дэвшинэ гэдэг бол бас би их олзуурхууштай л гэж бодож байна. Шударга шийдвэр тэндээс гарахад, хууль номыг дээдлэхэд бол манай Өлзийсайхан даргын ҮХЦ-д оруулах хувь нэмэр би өндөр гэж ингэж бодож байна. Тэгээд асуух асуулт алга. Өлзийсайхан даргадаа бол өндөр амжилт хүсэж байна. Улам их амжилт гаргаарай, бүтээлүүдээ нэмж туурвина байх гэж ингэж бодож байна. Тэгээд нийт эмэгтэй гишүүдийнхээ өмнөөс талархал илэрхийлж байна. Амжилт хүсье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Доржханд гишүүн асуулт. Сарангэрэл гишүүн санал хэлчихлээ тийм ээ.

**Т.Доржханд:** Баярлалаа. Нөгөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлэх би бол ҮХЦ дээр яг 2, 3 иргэний мэдээлэл гаргаж байсан. Тэгээд 01, 02 дугаар шийдвэр гээд. Тэгээд тэндээс бол дүгнэсэн зүйл бол ҮХЦ бол яалт ч байхгүй биеэ даасан байх ёстой, мэргэжлийн байх ёстой. Тэгээд зөвхөн хуульчаас гадна бас илүү нөгөө философийн утга агуулгаа ойлгодог ийм байх ёстой юм байна гэдэг тийм дүгнэлттэй болсон. Тэгээд сая бас Мөнх-Оргил гишүүн бид 2 бас ярьж л байсан билээ. Маргаантай асуудлууд байна гээд. Тийм. Тэгэхээр нөгөө тийшээгээ очиж байгаа хүн бол маш их тийм ёс зүйн болоод хууль зүйн их тийм өндөрлөгтэй байж л энэ парламентын ардчиллыг хамгаалах, Үндсэн хуулиа хамгаалах ажлыг хийх юм байна л гэсэн итгэл үнэмшил бол байна.

Тэгэхээр хувь хүний хувьд бол дэмжиж байна. Яагаад вэ гэхээр Цэцийн 9 гишүүний нэг нь эмэгтэй юм байна лээ. Тэгээд би бас Сарангэрэл гишүүнтэй бас санал нэг байна. Түүн дотор бол илүү бас харьцаагаа бол хадгалаад явах нь бол зүйтэй байх. Гэхдээ нөгөө талдаа нөгөө улс төрийн нөлөөлөл гэдэг юм юу билээ гэдэг асуулт байна л даа. Тэгэхээр та

нөгөө хараат бусаар, яг л нөгөө мэргэжлийн байдлаар үйл ажиллагаа явуулж чадах уу гэдэг тэр амыг нь 1 дүгээрт асуучихмаар байна.

Тэгээд 2 дугаарт нөгөө Америкийн бас нөгөө ардчиллын давуу тал нь юу вэ гээд Америкийн тэр хамгийн настай Цэцийн гишүүн, Дээд шүүхийн гишүүн байсан эд нар хуульчтай нь ярихаар нэг л юм байдаг юм. Тэр бол хараат бус, бие даасан, Америкийн Ерөнхийлөгчийг урдаа авчраад асууж чаддаг, шаардлагатай бол *it reach* хийж чаддаг, тэгээд ажлаас нь чөлөөлөх ийм хүмүүс л байдаг юм. Тэрний гол онцлог нь юу вэ гээд тэгэхээр бүх насаараа сонгогддог, томилогддог ийм албан тушаал байдаг юм гээд. Гэтэл манайх чинь бол 6 жил, 2 удаа билүү дээ. Тэгэхээр цаашаагаа нөгөө яг энэ асуудал дээр ямар байр суурьтай байдаг юм бэ? Тэгээд гол нь энэ нөгөө парламентын Тамгын газрын даргаар ажиллаж байсан, одоо ингээд нөгөө талдаа парламентын асуудлуудыг шийдэх, парламентын гишүүдтэй мэтгэлцээнийг нь шийдвэрлэх ийм л ажил дээр очихоор байна л даа. Тэгэхээр нөгөө нэг талыг барьсан биш яг илүү нөгөө зарчмаа бариад ажиллах тэр боломж бололцоо нь юу билээ гэдэг дээр нэг саналаа хэлээч. Байр сууриа, баярлалаа.

**Н.Энхболд:** Нэр дэвшигч Өлзийсайхан 2 номерын микрофон.

**Л.Өлзийсайхан:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Үндсэн хууль гэдэг бол өөрөө Үндсэн хуулийн зорилго, зориулалт гэдэг бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, мөн төрийн аливаа дур зоргыг хязгаарлахад бол оршиж бол байдаг. Тийм учраас Үндсэн хуулийн үзэл санаа, түүний хэм хэмжээг тайлбарлан хамгаалдаг оюун ухааны онолын шүүх гэж бол би өөрөө боддог юм байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэгд бол ҮХЦ гэдэг байгууллагыг бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавина мөн түүний заалтыг зөрчсөн

тухай дүгнэлт гаргана, магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн гэж ингэж хуульчилсан байгаа. Тэгэхээр ҮХЦ, түүний гишүүн гэдэг бол өөрөө Монгол Улсын Үндсэн хуульдаа захирагдана гэсэн үг. Хараат бус байна гэсэн үг. Тэгэхээр миний хувьд бол асуусан асуултад хариулахад би бол Үндсэн хуулийнхаа зарчимд захирагдана. Мөн би Үндсэн хуульдаа захирагдана. Мөн би хуульч гэсэн мэргэжилдээ би бол захирагдана. Тэгэхээр хараат бус ажиллаж чадна гэдгээ хэлье.

2 дугаар асуудал бол ҮХЦ бол 6 жилийн хугацаатай гишүүнийг бол томилдог ийм байгууллага бол байгаа. Гэхдээ мэдээж улс орны хувьд бол Үндсэн хуулийн шүүхийн загвар бол өөр өөрөөр бол ингэж хэрэгжиж бол ирдэг. Насан туршийн томилгоо бол байгаа, мөн тодорхой хугацаанд бас ингэж томилж эрх мэдлийг хэрэгжүүлж Үндсэн хуулийн манаачаар бол ингэж албаны болоод хувийн хараат бус байдлын энэ зан төлөвтэй ийм мэргэжсэн ийм хүмүүсийг бас томилдог байгаа. Тэгэхээр манай улсын хувьд бол Европын Үндсэн хуулийн шүүхийн загвартай бол байгаа. Тэгэхээр миний хувьд бол энэ загвар нь бол илүү оновчтой гэж бол ингэж үздэг юм. Судлаач хүний хувьд.

**Н.Энхболд:** Болсон уу? Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Би байна Пүрэвдорж гишүүнээр, Мөнх-Оргил, та кнопоо дараарай. Пүрэвдорж, Мөнх-Оргил, Тогтохсүрэн энэ 3 гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгээд ёстой нэг 3 жил энэ ард түмний болон Их Хурлын гишүүдийн ой тойнд ортол ярьж байж би энэ хуурамч шатахууны эсрэг хуулийг батлуулсан юм. Тэгээд манай ард түмэн машин тэргээ эвдлэхгүйгээр, дээрээс нь хорт бодис амьсгалахгүйгээр 2 жилийн туршид цэвэр шатахуун хэрэглээд явж байсан чинь өнгөрсөн 6 сард ҮХЦ өөртөө

ямар ч хамааралгүй асуудлаар энэ хуурамч шатахууны хуулийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаад, тэгээд тэрний нэг 5 нөхрийн 4 нь дээрэмчин байгаа, улаан цагаан луйварчингууд байгаа. Тэд нарын хэд нь явж байгаа юм бол? Тэгээд энэ хүмүүс ингээд миний тэр ард түмний төлөө батлуулсан хуулийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаад, тэрнийг нь Их Хурлын гишүүд хүлээж аваад авсан байгаа. Тэгэхээр би нэг зүйлийг л хэлье. Ер нь бол үнэхээр энэ дээр, дооргүй бүх одоо энэ албан газар, энэ төрийн байгууллагууд дээр бол үнэхээр энэ тийм мөнгө төгрөг харсан, ард түмнийхээ эсрэг ийм л зүйлийг хийсэн тийм бүх ийм хүмүүс хаа сайгүй бий болчхож дээ. Тэгээд энэ дээрээ тэгээд нөгөө нэг нүүрсний хулгай, төмөр замын хулгай, тэгээд л юу яадаг юм янз янзын хулгай хийгээд байхаар доод талын хүмүүс нь би ч гэсэн яадаг юм гээд ийм байдалтай болчихсон юм уу л гэж би бодоод байгаа юм.

Тийм учраас энэ дээр эмэгтэйчүүд бол нэг тийм арай нэг тийм янз янзын юманд автах нь их бага гэж би боддог. Тийм учраас эмэгтэйчүүдийг дандаа дэмждэг. Тэгээд одоо тэрний нэг миний хуулийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргасан 5 хүний нэг нь Баясгалан гээд тэр хүн бол энэ бол яалт ч үгүй Үндсэн хуулийн асуудал биш байна гээд эсрэг санал гаргаж, эсрэг эсэргүүцсэн байгаа. Үлдсэн 4 нөхөр бол үл бүтэх нөхдүүд байгаа. Тэр 4-ийн янз янзын үл бүтэх зүйлд битгий автаад явчхаарай л гэж би танд захих байна.

**Н.Энхболд:** Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Өлзийсайхан даргаа дэмжиж байна. Би би боддог юм. Цэцийн гишүүн бол хууль зүйн болон улс төрийн зөвхөн хууль зүйгээс гадна улс төрийн онолын болон практикийн их өндөр мэдлэгтэй хүн байх ёстой гэж. Бид нар энэ өндөр шалгуурыг болбол яг барьж байх ёстой. Манай Өлзийсайхан дарга бол энэ шаардлагыг бүрэн хангаж

байгаа юм. Онолын хувьд бол бас олон жил багшилсан доктор ийм хүн. Практикийн хувьд бол Улсын Их Хуралд 5 жил ажиллачихлаа. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нь шүү дээ. Их Хурлын ЕНБД чинь Их Хурлын гал тогоог барьдаг, энэ хуулиудыг үе шат бүхэнд нь хянадаг, эцэслэж бараг л дарга гарын үсэг зурах бүх юм бэлдэж өгдөг ийм л ажил шүү дээ. Тэгээд маш их нухлагдсан. Нөгөөдөх нь шүүх. Шүүхэд бас манай Өлзийсайхан дарга энэ нэлээн хэдэн жил ажилласан байна. Тийм учраас практикийн хувьд болбол би бүрэн тэнцэж байна гэж ингэж хэлэх гэж байгаа юм.

Бид энэ сүүлийн хэдэн жилд Үндсэн хуулийн 2 удаагийн өөрчлөлт хийгдсэн. Энэ өөрчлөлт хийгдэхэд манай бас Өлзийсайхан дарга голлож оролцсон. Судлаачийн хувьд голлож оролцсон. Тийм учраас болбол би ҮХЦ-ийн гишүүнээр энэ Үндсэн хуульдаа захирагдаж, Үндсэн хууль болон бусад хуулийг дагаж мөрдөж шударга ажиллана гэдэгт болбол итгэл төгс байгаа юм. Манай Өлзийсайхан даргад нэг сайхан чанар байгаа юм. Маш дайчин шуурхай, их ажилсаг хүн. Тэгээд энэ манай Мөнх-Оргил гишүүн хуулийг нь хийгээд бэлэн болгож байгаа гэж байгаа юм. Цэцийн хуулийг. Энэ процессуудыг нь бас сая манай Пүрэвдорж гишүүн ч яриад л байна. Энэ процессуудыг бид нар нэлээн тийм нарийн болгож өгөх ёстой Цэцийн. Тэгэхгүй бол хэт ерөнхий байгаад байгаа юм. Тийм. Тийм учраас бол ямар асуудал хэлэлцэх вэ, ямар процессоор явах вэ эд нарыг нь бол их нарийн болгож өгөх ёстой. Харин Мөнх-Оргил гишүүн энийг нэлээн хурдан өргөн барьчих ийм шаардлага байгаад байгаа юм. Ийм зүйлийг хэлье. Тэгээд Өлзийсайхан даргыг, манай энэ Их Хурлын гал тогоо л эзгүйрчхэж байгаа юм. Тэгэхдээ 1 бас бололцооны хүн олдох болов уу гэж ингэж бодож байна. Энэ Тамгын газрын дарга чинь их хэцүү ажил шүү дээ. Маш олон гишүүнтэй харилцдаг, их хэцүү ажил. Тэгээд энэ дээр бас дарга чухал хүн санал болгох байх,

бас чухал хүн томилох байх гэж ингэж бодож байна. Тэгээд Өлзийсайхан даргадаа амжилт хүсье. Цэцийн ажилд зүтгэж, энэ Монгол Улсын Үндсэн хуулийг хамгаалах энэ их үйлст нь бас амжилт хүсье.

**Н.Энхболд:** Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Цэцийн хууль, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны журмын тухай хууль гээд 2 том хууль дараагийн долоо хоногт Улсын Их Хурлын даргад өргөн баригдах байх. Дараагийн долоо хоног байна уу, тэрний дараагийн долоо хоногт. Энэ бол бид нар судлаачидтай хамтраад жил 6 сар болсон, нэлээн их хэлэлцүүлэг өрнүүлж, олон шинэлэг зүйлүүд оруулж байгаа ийм хууль өргөн баригдах байх гэж бодож байна. Мэдээллийн хувьд.

Миний гол хэлэх гэсэн юм би Өлзийсайхан нэр дэвшигчийг дэмжиж байна. Занданишатар дарга зөв хүн оруулж ирсэн байна гэж би бодож байна. Яагаад гэвэл энэ сүүлийн үед бид нар Улсын Их Хурлаас Цэцийн гишүүд нэр дэвшүүлж явуулж байгаа өөр институтүүдээс оруулж ирсэн нэрийг нь батлаад явуулж байгаа хүмүүс голцуу судлаач, багш талдаа нэлээн хандчих гээд байгаа, халаах гээд байгаа юм. Тэгэхээр мэдээж тэнд судлаач нар байх хэрэгтэй л дээ. Тэгэхдээ ямар ч байсан гэсэн талаас илүү хувь нь амьдралын хууль, эрх зүйн, улс төрийн практик туршилагатай хүмүүс байх хэрэгтэй байгаа юм. Тэгээд Өлзийсайхан нэр дэвшигч яг энэ 2 шаардлагыг аль алиныг нь хангаж байна. Өндөр мэргэжилтэй, эрх зүйч, дээр нь яг төрийн ажлын дадлага туршилагатай, практиктай хүн учраас энэ зөв томилгоо болох байх гэж би бодож байна.

Хоёрт нь Өлзийсайхан нэр дэвшигчид Цэцийн гишүүнээр томилогдоод очсон тохиолдолд нэг юман дээр бас анхаарч өгөөрэй гэж хүсэх гээд

байгаа юм. Энэ яг нөгөө ажлынхаа онцлогоос болоод Цэц, Их Хурал хоёрын хооронд нэг тийм үл ойлголцох явдлууд ер нь их байнга байгаад байдаг юм. Энэ бол ганцхан Монголд ч биш юм байна лээ л дээ. Бүх улс орнуудад ч гэсэн байдаг. Тэгэхдээ бүх улс орнуудад ялгаатай нь нөгөө жинхэнэ утгаараа шүүх гээд хүлээн зөвшөөрөгдчихсөн учраас нэг шийдвэр гаргаад л түс гээд л дуусчхаад байгаа байхгүй юу. Манайд болохоор энэ чинь яг шүүх гэдэг утгаараа одоо л ингээд л төлөвшөөд л энэ хууль, одоо бидний өргөн барьсан хуулийг Их Хурлаас баталчихвал жинхэнэ утгаараа яг шүүх гэдэг нь нөгөө хүлээн зөвшөөрөгдөөд, төлөвшөөд процесс нь тэгээд явах гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Их Хурлын гал тогоог барьж байсан хүний хувьд энэ 2 институтийн хоорондын харилцааг юу гэдэг юм нэг найзархаг биш болгоход ч хаашаа юм зүгээр, гэхдээ ямар ч байсан гэсэн харилцан ойлголцдог, харилцан хүндэтгэх түвшин дээр нь хүргэж өгөөрэй. Энэ манай Их Хуралд ч гэсэн бас дутагдалтай тал их байгаа юм. Нөгөө баталсан хуулийг нь Үндсэн хууль зөрччихлөө гээд дүгнэчихээр, энэ Үндсэн хууль зөрчөөгүй гэдгээ тийм, Үндсэн хууль зөрчөөгүй гэдгээ нотлох гээд тийм нэг сэтгэлийн хөдөлгөөн ихтэй реакциуд их гаргаад байдаг тал бий л дээ манай Их Хурлын зүгээс.

Гуравд нь энэ Цэцийн өмнө гаргасан дүгнэлтүүд дээр сая Пүрэвдорж гишүүн нэг чухал дүгнэлт ярилаа. Ер нь ч бас нэг хэд хэдэн дүгнэлтүүд байгаа юм. Би бол хувьдаа жишээ нь яагаад ч хүлээн зөвшөөрч чадахгүй дүгнэлтүүд. Тэгээд Цэцэд өөрт нь энэ өмнө гаргасан шийдвэрүүдээ эргээж харах механизмууд байгаа байхгүй юу. Тэрийгээ ерөөсөө хэрэглэдэггүй, ашигладаггүй. 1 удаа байна уу, 2 удаа л хэрэглэсэн. Өмнө гаргасан шийдвэрээ 2/3-ынхоо саналаар билүү дээ эргээж сөхөж үзээд, энэ ийм шийдвэр болсон байна, үр дагавар нь ийм байсан байна, энэ буруу байсан байна, энийг ингэх ёстой байсан байна гэж засах эрх нь

Цэцэд байгаа байхгүй юу. Жишээ нь саяын тэр Пүрэвдорж гишүүний яриад байгаа онцгой албан татвар ноогдуулахад аж ахуйн нэгжүүдийг хооронд нь ялгаварлан гадуурхсан байна гэж хэлээд Үндсэн хууль зөрчсөн гэдэг дүгнэлт гаргаж байгаа бол энэ ямар ч тохиолдолд, аль ч нийгэмд ҮХЦ-ийн хэлэлцдэг асуудал ч биш, гаргаж байгаа дүгнэлт нь бас арай л аймаар юм гаргаж байгаа байхгүй юу. Энэ чинь татвар чинь угаасаа л ялгаатай байна шүү дээ. Аж ахуйн нэгж янз, янз үйл ажиллагаа явуулна, төрийн бодлогын шаардлага гарах юм бол адилхан тохиолдолд ч гэсэн өөр, өөр татвар тогтоох гарцаагүй шаардлага ч гарч магадгүй шүү дээ. Тэгээд ийм юм гаргачихсан.

Тэгээд хамгийн аймар нь Цэц тийм дүгнэлт гаргачихаад байхад манай Их Хурал өөрөө хүлээгээд авчихсан л даа. Тэгээд 100 хувь Цэцийг бас буруутгаад байж болохгүй болчихоод байгаа юм. Цэц хүлээж юу, Цэцийн дүгнэлтийг Их Хурал хүлээж аваагүй буцаачихсан бол их суудлаар ямар ч шийдвэр гарах байсан юм бүү мэд. Тэгээд иймэрхүү хэд хэдэн асуудлууд бий. Энийг та хэд маань бас нэг шинэ бүрэлдэхүүнээрээ тал талаас нь эргээж харж, энэ орчин цагийн эрх зүйн онолын болон бусад энэ практик мэдлэг туршилагаа дайчлаад, эргээж харж үзнэ биз дээ гэж найдаж байна. Тэгээд таны ажилд амжилт хүсье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна, гишүүдээ анхааралтай байгаарай. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Л.Өлзийсайханыг нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72,7 хувиар саяын санал дэмжигдлээ. Нэр дэвшүүлэх тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг холбогдох Байнгын хороон дээр Хууль зүйн байнгын хороонд бид нар хүргүүлнэ. Мөнх-Оргил гишүүн тэнд танилцуулчихна биз. Тийм ээ.

*15.05 цаг*

*Өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа. Гишүүддээ баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ*

*БУУЛГАЖ, ХЯНАСАН:*

*ШИНЖЭЭЧ*

*Д.УЯНГА*